

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт

Хөвсгөл усан зам ХК 2022 оны 03 улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 09 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	"Хөвсгөл усан зам" ХК /17100001004, 000208370, 89885120/
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	"Хөвсгөл усан зам" ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Усан замын тээвэр, аялал жуулчлал
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	9,442,600 ширхэг
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ, хянасан Гүйцэтгэх захирал Ч.Үржинбадам
1	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт
	Орлогын тайлан
	Өмчийн өөрчлөлтийн тайлан
	Мөнгөн гүйлгээний тайлан
	2022 оны 3-р улирлын санхүүгийн тайлан тэнцлийг хавсаргав.
	2022 оны 3-р улирлын санхүүгийн тайлан тэнцлийг хавсаргав.
	2022 оны 3-р улирлын санхүүгийн тайлан тэнцлийг хавсаргав.
	2022 оны 3-р улирлын санхүүгийн тайлан тэнцлийг хавсаргав.
2	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргасан. Улирал болон хагас жилийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргаагүй.
3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт

3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	2022 оны 09 дугаар сарын 30-ны байдлаар 104 аялалаар 8192 аялагчдад үйлчилж, 253,929.8 мянган төгрөгийн орлоготой ажиллалаа.
3.2	Хөрвөх чадвар боломжийн үзүүлэлт болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Аялал жуулчлалын үйл ажиллагаа сэргэж усан зам тээврийн аялагчдын тоо өссөн.Орон нутагт 16 ажлын байрыг бий болгон үйл ажиллагаагаа явуулсан байна.
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	<p>Дэлхий нийтийг хамарсан цар тахалын улмаас 2 жил үйл ажиллагаа явуулаагүй. Хэвийн үйл ажиллагаан бэлтгэж засвар үйлчилгээ хийж, үйл ажиллагаа жигдрүүлж Зам тээврийн яамны далайн захиргааны газар, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын шалгалтанд орж зөвшөөрөл, техникийн хяналтын үзлэгт тэнцсэн. 022 оны 2 дугаар сард Сүхбаатар усан онгоцны ёроолын зузаан, зэврэлтийг мэргэжлийн лабораториор 2,900.0 мянган төгрөгөөр оношлуулсан.</p> <p>1.Усан онгоцны хэвийн жигд үйл ажиллагааг хангахын тулд Зүүн хөдөлгүүрийн ус масло холилдсоныг задалж, бүх маслыг сольсон.</p> <p>2.Сантехникийн угсралтуудыг дахин хийж, хоолойнуудыг шалгаж гагнасан. 3.Сэнсний жийрэгүүдийг сольсон.</p> <p>4.Моторын кропнуудыг холбосон.</p> <p>5.Онгоцны дээд давхарын гэрэлтүүлэг 500вт 6 ш, дотор моторын өрөөний гэрэлтүүлэг 60 вт 120ш шинэчлэсэн. 8ш аврах цагригт уяа холбоос хийсэн.</p> <p>6. Онгоцны урд хэсэгт ус дүүрч байсныг усыг шавхаж татаж нүх үүссэн байсныг гагнаж засварласан. Одоо мөс хөлдөх хүртэл тогтмол хяналт тавьж байна.</p> <p>Усан онгоцны 104 удаагийн аялал хийхэд түлшний зардалд 63,684,600 төгрөг, моторын маслоны зардалд 1,660,900 төгрөг гаргаж, нийт аялагч амрагчдад үйлчилсэн байна.</p> <p>Усан онгоцны бохирын шланжыг шинэчлэж сольсон.</p> <p>Онгоцны үзелийн пульт 1,800.0 мянган төгрөгөөр, микрофон 95.0 мянган төгрөгөөр , чанга яригч 1,100.0 мянган төгрөгөөр, 4ш богино долгионы станц 580.0 мянган төгрөгөөр тус тус авч шинэчилсэн.</p> <p>Онгоцны зогсоолын тавцангийн засвар</p> <p>1. Сүхбаатар онгоцны зогсоолын тавцангийн</p>

		<p>245м2 талбай элэгдэж, эвдэрснийг 42,250.0 мянган төгрөгөөр засварласан.</p> <p>2.Нурсан хэсгийн 254м2 талбайн банзыг хуулж, хадаасыг авч хугарсан няцарсан банзыг ялгаж, шинэчлэсэн.</p> <p>3.Хугарч ялзарсан дүнзийг мөснөөс гарган, шинэ дүнзийг холтослон хувааж, мөсөн дотор оруулж, хайрцаглан тэгшилж бэхэлсэн.</p> <p>4.Зогсоолын дунд хэсгийн доошоо цөмөрч орсон хэсгийг нөхөж засан, дээшлүүлэн тэгшилж бэхэлгээ хийсэн.</p> <p>5.Дээд тавцангийн банзны хугарсан, муудсан хэсгийг ялгаж засварлан зарим хэсгийг шинэ банзаар сольсон.</p> <p>6.Тавцангийн дээд хэсгийг бүрэн банзаар хадаж бэлэн болгон үйл ажиллагаа явуулахад боломжтой болгосон.</p> <p>7.Бохирын машин ордог хэсгийг бэхлэж, шинэ банзаар бэхэлгээ хийсэн.</p>
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
		ТУЗ-ийн хараат бус гишүүдийн 2022 оны 02-р сарын 09-ний өдрийн хурлын 22/02 дугаартай тогтоолын дагуу "Номин холдинг" ХХК-иас 166,166,552 төгрөгийн зээл авах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн.
5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Хувьцаа нэмж гаргаагүй	
6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	<p>➢ "Хөвсгөл усан зам" ХК нь компанийн засаглалын бүтцийн хувьд дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хувьцаа эзэмшигчдийн хурал, - Төлөөлөн удирдах зөвлөл, - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, - Гүйцэтгэх захирал, - Ахмад-манаач - Нярав-ЗБ 	

- Механик-цахилгаанчин

- Ахмадын туслах-завьчин

- Жолооч мужаан

- Туслах механик

- Сантехникч

- Хамгаалагч

- Кассчин, онгоцны үйлчлэгч, уяа оосрын туслах ажилтан, зочид буудалын үйлчлэгч, үзель техникийн ажилтан

➤ Тайлант хугацаанд компанийн удирдлагын хүрээнд дараах үйл ажиллагаа явагдсан.
Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04-р сарын 25-ны өдөр хуралдаж, компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт болон ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг баталсан.

- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 2022 оны 01-р сарын 07-ны өдөр хуралдаж компанийн жилийн үйл ажиллагааны тайланд хөндлөнгийн аудит хийх аудитын байгууллагыг сонгосон.

- ТУЗ-ийн хараат бус гишүүд 2022 оны 01-р сарын 26-ны өдөр хуралдаж "Номин холдинг" ХХК-иас зээл авах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

- Төлөөлөн удирдах зөвлөл 2022 оны 02-р сарын 09-ний өдөр хуралдаж өнгөрсөн оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Мөн компанийн 2022 оны зардлын төсвийг баталсан.

- Төлөөлөн удирдах зөвлөл 2022 оны 03-р сарын 18-ны өдөр хуралдаж 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов болон хэлэлцэх асуудлыг баталсан.

- Төлөөлөн удирдах зөвлөл 2022 оны 02-р сарын 15-ны өдөр хуралдаж компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэсэн, мөн компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг баталсан.


7 Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн зүгээс хувьцаа болон бусад төрлийн үнэт цаас нэмж гаргах, өрийг хувьцаагаар солих, компани хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авах зэрэг үйл ажиллагаа явагдаагүй болно.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ч.Үржинбадам

Албан тушаал: "Хөвсгөл усан зам" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: 

(Тамга/тэмдэг)

ХӨВСГӨЛ АЙМАГ

УСАН ЗАМ

ХК

ATA1378 2024786

Овог нэр: М.Өлзийбат

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: 

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2022/10/20

Овог, нэр: Д.Чимгээ

Албан тушаал: Ахлах нягтлан бодогч

Гарын үсэг: 